



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/351

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 58 дугаар зүйлийн 58.2.13, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батширээт сумын нутаг “Гутайн даваа” гэх газарт хамгаалалтын арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах хоол болон шатахуунд 1 746 576 (нэг сая долоон зуун дөчин зургаан мянга таван зуун далан зургаан мянган) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулах төсвийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ